



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 23 (308)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Хуульчдаас сонгон шалгаруулах тухай*
- *Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай*
- *Агаарын зайг нисэхэд ашиглах тухай*
- *Улсын нисэхийн тухай хууль*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2003 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны зургадугаар сарын 17

№ 23 (308)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

|      |   |                      |     |
|------|---|----------------------|-----|
| 331. | Хуульчдаас сонгон шалгаруулах тухай                                   | (2003-5-22-ны хууль) | 538 |
| 332. | Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | (2003-5-30-ны хууль) | 541 |
| 333. | Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай             | (2003-5-30-ны хууль) | 541 |
| 334. | Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай    | (2003-5-30-ны хууль) | 542 |
| 335. | Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай             | (2003-5-30-ны хууль) | 542 |
| 336. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай         | (2003-5-30-ны хууль) | 542 |
| 337. | Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай                        | (2003-5-30-ны хууль) | 542 |
| 338. | Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай           | (2003-5-30-ны хууль) | 543 |
| 339. | Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                | (2003-5-30-ны хууль) | 543 |
| 340. | Шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай                             | (2003-5-30-ны хууль) | 543 |
| 341. | Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай                      | (2003-5-30-ны хууль) | 543 |
| 342. | Агаарын зайг нисэхэд ашиглах тухай                                    | (2003-5-30-ны хууль) | 549 |
| 343. | Улсын нисэхийн тухай хууль  | (2003-5-30-ны хууль) | 552 |
| 344. | Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай          | (2003-5-30-ны хууль) | 555 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

|      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 345. | Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай | Дугаар 20 | 556 |
| 346. | Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай                | Дугаар 21 | 556 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ХУУЛЬЧДААС СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаал эрхлэх сонгон шалгаруулалтад оролцох, өмгөөллийн болон нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар ажиллах хуульчдыг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль тогтоомж

2.1. Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Шүүхийн тухай<sup>2</sup>, Прокурорын байгууллагын тухай<sup>3</sup>, Өмгөөллийн тухай<sup>4</sup>, Нотариатын тухай<sup>5</sup>, Цагдаагийн байгууллагын тухай<sup>6</sup>, Тагнуулын байгууллагын тухай<sup>7</sup>, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай<sup>8</sup> хууль болон энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "хуульчаар ажиллах эрх авсан этгээд" гэж энэ хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан этгээдийг;

*Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2003 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хориг таавсан тул үе хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэлтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно./*

3.1.2. "хуульчдын сонгон шалгаруулалт" гэж шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаал эрхлэх сонгон шалгаруулалтад оролцох, өмгөөллийн болон нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар ажиллах хуульчдаас мэргэжлийн хангалттай мэдлэг, чадварыг эзэмшсэн эсэхийг шалгаж, гэрчилгээ олгох ажиллагааг.

#### 4 дүгээр зүйл. Хуульчдаас сонгон шалгаруулах үйл ажиллагааны зарчим

4.1. Хуульчдаас сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө, ил тод байдал, тэгш эрх, шударга ёсыг хангах, хууль дээдлэх, хараат бус байх, нууцыг чандлан хадгалах, шударга өрсөлдөөний зарчмыг баримтална.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ

##### Хуульчдаас сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах

#### 5 дугаар зүйл. Орон тооны бус зөвлөл

5.1. Хуульчдаас сонгон шалгаруулах ажлыг орон тооны бус зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.

5.2. Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга тэргүүлэх ба бүрэлдэхүүнд нь Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Монголын өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч, Нотариатчдын танхимын Ерөнхийлөгч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгжийн дарга орно.

#### 6 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх

6.1. Зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. хуульч боловсон хүчнийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдсон асуудлаар бодлого боловсруулах;

6.1.2. сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдон журам, заавар тогтоох;

6.1.3. хуульчдын сонгон шалгаруулалт /цаашид "сонгон шалгаруулалт" гэх/ явуулах газар, хугацааг товлон, зарлах;

6.1.4. энэ хуулийн 12, 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд сонгон шалгаруулалтад оролцох эрх олгох буюу татгалзах;

6.1.5. сонгон шалгаруулалтын даалгавар боловсруулах ажлыг зохион байгуулах;

6.1.6. сонгон шалгаруулалтын явцад хяналт тавих;

6.1.7. сонгон шалгаруулалтад ашиглах, туслах материалын жагсаалт гаргах;

6.1.8. сонгон шалгаруулалттай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх;

6.1.9. шалгалтын хорооны бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх;

6.1.10. сонгон шалгаруулалтын дүнг мэдээлэх;

6.1.11. сонгон шалгаруулалтад

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эхлэлтэй 1992 оны 1 дүгээр нийтлэгдсэн.

<sup>2</sup> Шүүхийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эхлэлтэй 2002 оны 29 дүгээр нийтлэгдсэн.

<sup>3</sup> Прокурорын байгууллагын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эхлэлтэй 2002 оны 29 дүгээр нийтлэгдсэн.

<sup>4</sup> Өмгөөллийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эхлэлтэй 2002 оны 21 дүгээр нийтлэгдсэн.

<sup>5</sup> Нотариатын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эхлэлтэй 1997 оны 8 дүгээр нийтлэгдсэн.

<sup>6</sup> Цагдаагийн байгууллагын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эхлэлтэй 1993 оны 9 дүгээр нийтлэгдсэн.

<sup>7</sup> Тагнуулын байгууллагын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эхлэлтэй 1999 оны 35 дүгээр нийтлэгдсэн.

<sup>8</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - "Төрийн мэдээлэл" эхлэлтэй 2002 оны 9 дүгээр нийтлэгдсэн.

тэнцсэн этгээдэд гэрчилгээ олгох;

6.1.12.Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон журам тогтоох;

6.1.13.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

6.2.Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд шийдвэрээ олонхийн саналаар гаргана.

## 7 дугаар зүйл. Зөвлөлийн ажлын алба, түүний чиг үүрэг

7.1.Зөвлөлийн ажлын албаны үүргийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж гүйцэтгэж, дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1.хуульч боловсон хүчнийг бэлтгэх, сонгон шалгаруулах асуудлаар Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.2.хуульч боловсон хүчний улсын нэгдсэн бүртгэл, судалгаа хөтлөх, ойрын болон хэтийн нөөцийн судалгаа хийх;

7.1.3.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

## 8 дугаар зүйл. Шалгалтын хороо

8.1.Шалгалтын хороо /цаашид "хороо" гэх/ нь шүүх, прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон өмгөөллийн байгууллагад ажиллаж байгаа хуульч, эрх зүйн салбарын багш, эрдэмтэд /цаашид "шалгагч" гэх/-ээс бүрдэнэ.

8.2.Хорооны бүрэлдэхүүнийг Зөвлөл сонгон шалгаруулалт явуулах бүрт томилох бөгөөд шалгагчдын нэрсийн жагсаалт нь сонгон шалгаруулалт явуулах өдөр, цаг хүртэл байгууллагын нууцад хамаарна.

8.3.Хороо нь Зөвлөлөөс баталсан журмын дагуу дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.3.1.сонгон шалгаруулалтад оролцогчийн даалгаврын гүйцэтгэлийг хянаж, дүгнэх;

8.3.2.шалгалтын дүнг нэгтгэн Зөвлөлд хүргүүлэх.

8.4.Хорооноос энэ хуулийн 8.3-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь аливаа байгууллага, албан тушаалтан хөндлөнгөөс оролцох буюу нөлөөлөхийг хориглоно.

8.5.Хороо нь сонгон шалгаруулалттай холбогдон үүссэн маргаантай асуудлаар Зөвлөлд санал оруулах эрхтэй.

8.6.Хорооны гишүүдэд урамшуулал олгох бөгөөд түүний хэмжээг хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллага хамтран тогтооно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Хуульчдаас сонгон шалгаруулах журам

#### 9 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалт

9.1.Сонгон шалгаруулалт нь эрх зүйн салбарын хүрээнд тодорхой өгөгдлийг хууль хэрэглэж шийдвэрлэх бодлого болон ярилцлагын хэлбэртэй байна.

9.2.Сонгон шалгаруулах шалгалт /цаашид "шалгалт" гэх/-ын үргэлжлэх нийт хугацаа гурав хоног байна.

9.3.Шалгалтад авбал зохих нийт онооны 70-аас доошгүй хувийг авсан тохиолдолд тухайн шалгалтад тэнцсэнд тооцно.

9.4.Шалгалтын нэгдсэн дүнг шалгалт дууссаны дараа нууцалсан дугаараар гаргаж, мэдээлнэ.

#### 10 дугаар зүйл. Сонгон шалгаруулалт явуулах газар, хугацаа

10.1.Зөвлөл сонгон шалгаруулалт явуулах газар, хугацааг жилд нэг удаа төвлөн зарлана.

10.2.Зөвлөл сонгон шалгаруулалтыг улсын хэмжээнд зэрэг эхэлж, дуусахаар зохион байгуулна.

10.3.Өмнөх жилийн сонгон шалгаруулалт явуулснаас хойш 10-аас доошгүй сарын дараа тухайн жилийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

10.4.Шалгалт эхлэхээс 45-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын товыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

10.5.Сонгон шалгаруулалтын товд шалгалтын хуваарь, бүртгэх, шалгалт авах газар, хугацаа, шалгалтын дарваллыг заана.

#### 11 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалтын даалгавар

11.1.Зөвлөл сонгон шалгаруулалтын даалгавар, түүний хариултыг хуульч, эрх зүйн салбарын багш, эрдэмтдээр гэрээний үндсэн дээр урьдчилан бэлтгүүлэн авч болох бөгөөд энэ нь сонгон шалгаруулалт явуулах өдөр, цаг хүртэл байгууллагын нууцад хамаарна.

11.2.Тухайн жилийн сонгон шалгаруулалтын даалгавар нь орон даяар ижил байна.

11.3.Сонгон шалгаруулалтад оролцогчийн даалгаврын гүйцэтгэлийн хуудсыг нууцалсан тоогоор дугаарлах бөгөөд дугаартай холбогдох нэрсийн жагсаалт нь байгууллагын нууцад хамаарна.

11.4.Сонгон шалгаруулалтын даалгаврыг гурваас доошгүй шалгагчийн бүрэлдэхүүнтэйгээр



дүгнэх ба дүнг тэдгээрээс өгсөн үнэлгээний дунджаар гаргана.

## 12 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтад оролцох

12.1 Дараахь шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн сонгон шалгаруулалтад оролцоно:

12.1.1. Монгол Улсад эрх зүйн чиглэлээр суралцаж бакалаврын болон түүнээс дээш зэргийн боловсрол эзэмшсэн;

12.1.2. ял шийтгэлгүй;

12.1.3. сүүлийн 1 жилд ёс зүйн зөрчил гаргаагүй.

*Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2003 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.*

12.2. Гадаад улсад эрх зүйн чиглэлээр суралцаж бакалаврын зэргийн диплом авсан, энэ хуулийн 12.1.2, 12.1.3-т заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй.

## 13 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтад оролцох тухай өргөдөл гаргах

13.1. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан этгээд Зөвлөлд хандаж сонгон шалгаруулалтад оролцох тухай өргөдөл гаргана.

13.2. Өргөдлийг сонгон шалгаруулалтын товыг зарласан өдрөөс эхлэн хүлээн авч, шалгалт эхлэхээс ажлын 7 өдрийн өмнө дуусгавар болгоно.

13.3. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөлд дараахь баримт бичгийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн хавсаргана:

13.3.1. Монгол Улсын иргэний үнэмлэх, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний хувьд гадаад улсын паспорт болон түүнийг орлох хууль ёсны баримт бичиг;

13.3.2. эрх зүйн бакалаврын болон түүнээс дээш боловсролын зэргийн диплом;

13.3.3. ял шийтгэлгүй болохыг нотолсон эрх бүхий байгууллагын тодорхойлолт.

## 14 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах

14.1. Дараахь үндэслэл байвал Зөвлөл сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах эрхтэй:

14.1.1 хүсэлт гаргагч энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

14.1.2. энэ хуулийн 13.3-т заасан

баримт бичгийг бүрдүүлээгүй буюу хуурамчаар бүрдүүлсэн;

14.1.3 сонгон шалгаруулалтын товд заасан хугацаанд бүртгүүлээгүй.

## 15 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтад дахин оролцох

15.1. Сонгон шалгаруулалтад тэнцээгүй этгээд сонгон шалгаруулалтад дахин оролцох эрхтэй.

## 16 дугаар зүйл. Гэрчилгээ олгох

16.1. Зөвлөл сонгон шалгаруулалтад тэнцсэн этгээдэд гэрчилгээ олгох бөгөөд түүний загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.2. Хуулийн их, дээд сургуулийн профессор багш, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан этгээд өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд түүнд энэ хуулийн 16.1-д заасан гэрчилгээ олгох асуудлыг Зөвлөл шийдвэрлэнэ.

*Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч 2003 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.*

16.3. Гэрчилгээ авсан этгээд нь энэ хуулийн 1.1-д заасан ажил, албан тушаал эрхлэх бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сонгон шалгаруулалтад орох буюу тусгай зөвшөөрөл авна.

16.4. Гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, нотариатч, шийдвэр гүйцэтгэгчээр, гадаадын иргэн, харьяалалгүй хүн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мэргэшлийн шалгалт өнө.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

## 17 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтын санхүүжилт

17.1. Сонгон шалгаруулалтад оролцох нэг оролцогчид ногдох зардлын хэмжээг санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно.

17.2. Сонгон шалгаруулалтад оролцогч энэ хуулийн 17.1-д заасан зардлыг өөрөө хариуцна.

## 18 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтын нууцыг хамгаалах

18.1. Энэ хуулийн 8.2, 11.1, 11.3-т заасан этгээд сонгон шалгаруулалтын нууцыг задруулахыг хориглоно.



18.2.Энэ хуулийн 18.1-д заасан сонгон шалгаруулалтын нууцыг задруулсан этгээдийг сонгон шалгаруулалтын бүхий л үйл ажиллагаанд оролцуулахгүй.

### 19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Энэ хуулийн 18.1-д заасан сонгон шалгаруулалтын нууцыг задруулсан этгээдийг 60000 төгрөгөөр торгоно.

### 20 дугаар зүйл. Сонгон шалгаруулалттай холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэх

20.1.Сонгон шалгаруулалтад оролцогч нь сонгон шалгаруулалттай холбоотой гомдлоо тухайн шалгалтын дүн гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор Зөвлөлд бичгээр гаргана.

20.2.Зөвлөлд энэ хуулийн 20.1-д заасан гомдлыг хүлээж авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ.

20.3.Гомдол гаргагч Зөвлөлийн шийдвэрийг үл зөвшөөрвөл шүүхэд хандаж болно.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### ХУУЛЬЧДААС СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө ажиллаж байгаа шүүгч, прокурорт Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Шүүхийн мэргэшлийн хорооны, Прокурорын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан гэрчилгээ олгоно.

Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан гэрчилгээ олгоно.

**2 дугаар зүйл.** Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө өмгөөллийн болон нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан өмгөөлөгч, нотариатчид Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Сахилгын хорооны, Нотариатын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д заасан Нотариатчдын танхимын дүгнэлтийг үндэслэн

**3 дугаар зүйл.** Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн үнэлгээг нь үндэслэн Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан гэрчилгээ олгоно.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийн 1, 2 дугаар зүйлд заасан дүгнэлтийг 2004 оны 10 дугаар сарын 1-ний дотор Хуульчдаас сонгон шалгаруулах ажлыг эрхлэн гүйцэтгэх орон тооны бус зөвлөлд ирүүлнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 17.9, 17.10 дахь хэсэг нэмсүгэй:

"17.9.Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтад орж тэнцэн гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаалд ороход энэ хуулийн 17.3-т заасан мэргэшлийн шалгалтаас чөлөөлөгдөнө.

17.10.Энэ хуулийн 17.9-д заасан албан тушаалд ажиллаж байгаа этгээд төрийн жинхэнэ албаны өөр албан тушаалд шилжиж ажиллахад төрийн албаны мэргэшлийн шалгалт өгнө."

**2 дугаар зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8-ын "болон" гэсний дараа "энэ хуулийн 17.9-д зааснаас бусад" гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9-17.11 дэх хэсгийн дугаарыг "17.11-17.13" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Тагнуулын байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлд "Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан иргэнийг тагнуулын байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар томилно." гэсэн 17.2 дахь хэсэг нэмсүгэй.

хэсгийн дугаарыг "17.3-17.8" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Тагнуулын байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-17.7 дахь

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан иргэнийг цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар томилно." гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132.4-ийн "хууль зүйн дээд боловсролтой" гэснийг "Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нотариатын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтад орж тэнцсэн хуульч" гэснийг "Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан иргэн" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Прокурорын байгууллагын тухай хуулийн 39.1, 45.1-ийн "Хууль зүйн бакалаврын боловсролтой" гэснийг "Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Өмгөөллийн тухай хуулийн 16.4-ийн "Монгол хэл мэддэг" гэсний дараа "Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан" гэж нэмсүгэй.

шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан этгээд" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Өмгөөллийн тухай хуулийн 5.1-ийн "Хууль зүйн дээд боловсролтой", 16.2-ын "Хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтад орж тэнцсэн хуульч" гэснийг "Хуульчдаас сонгон

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн тухай хуулийн 28.1-д "Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан" гэсэн 28.1.3 дахь заалт нэмсүгэй.

сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульчдаас

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл  
**1 дүгээр зүйл.** Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын

нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх



харилцааг зохицуулахад оршино.

## 2 дугаар зүйл. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль тогтоомж

2.1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

## 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "бүсийн хөгжлийн тулгуур төв" гэж тухайн бүсийг гадаад, дотоод зах зээлтэй холбоход байгаль, эдийн засгийн нөхцөлийн хувьд тохиромжтой байрласан улсын зэрэглэлтэй хотыг;

3.1.2. "орон нутгийн хөгжлийн төв" гэж тухайн бүс нутгийн хүн амын нийгэм, эдийн засгийн хөгжилд голлох үүрэгтэй, үйлдвэрлэл, үйлчилгээний дэд бүтэц бүхий аймгийн зэрэглэлтэй хотыг.

## 4 дүгээр зүйл. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үндсэн зарчим

4.1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

4.1.1. үндэсний эрх ашгийг эрхэмлэн дээдлэх;

4.1.2. бүс нутгийн нийгэм, соёлын харьцангуй жигд хөгжлийг хангахад чиглэсэн эдийн засгийн нэгдмэл орчныг бүрдүүлэх;

4.1.3. хүн амын нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, соёл, боловсролын үйлчилгээг тухайн бүс дотор нь аймаг, орон нутгийн чадавхид түшиглэн цогцолбороор шийдвэрлэх;

4.1.4. бүс нутгийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын

хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлж, тэдгээрийн бие даан хөгжих боломжийг хангах;

4.1.5. нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг хүндэтгэх, тэдгээрийн онцгой бүрэн эрхэд хамаарах асуудалд хөндлөнгөөс үл оролцох;

4.1.6. эдийн засгийн өсөлтийг хангахад голлох үүрэг бүхий бүс нутгийг түлхүү анхаарч хөгжүүлэх.

## 5 дугаар зүйл. Эдийн засгийг бүсчилэн зохицуулах үйл ажиллагааны шалгуур

5.1. Энэ хуульд заасны дагуу бүс нутгийг зохион байгуулахдаа дор дурдсан шаардлагыг үндэс болгоно:

5.1.1. байгаль орчиндоо зохицсон эдийн засгийн оновчтой бүтэцтэй байх;

5.1.2. үйлдвэрлэл, үйлчилгээний тодорхой салбарыг тэргүүлэх чиглэлээр хөгжүүлсэн байх;

5.1.3. бүс нутаг хоорондоо болон дотоод, гадаад зах зээлтэй дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэгээр холбогдсон байх;

5.1.4. бүсийн тулгуур төвтэй байх.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалт

## 6 дугаар зүйл. Үндэсний хороо

6.1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хороо Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

6.2. Үндэсний хороо нь дараахь бүрэлдэхүүнтэй байна:

6.2.1. Үндэсний хорооны дарга, орлогч дарга;

6.2.2. Засгийн газрын гишүүн-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;

6.2.3. байгаль орчин, дэд бүтэц, хүнс,



хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд;

6.2.4. энэ хуулийн 6.2.3-т зааснаас бусад яамдын Төрийн нарийн бичгийн дарга;

6.2.5. бүсийн Зөвлөлийн дарга нар.

6.3. Үндэсний хорооны дарга нь Ерөнхий сайд, орлогч дарга нь бус нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

6.4. Бүсийн зөвлөлийн дарга нараас бусад Үндэсний хорооны гишүүдийг Үндэсний хорооны дарга томилж, чөлөөлнө.

6.5. Үндэсний хороо нь ажлын албатай байна. Ажлын албаны үүргийг Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн стратеги, төлөвлөлтийн алба хэрэгжүүлнэ.

6.6. Үндэсний хорооны дүрэм, ажиллах журмыг Засгийн газар батална.

## 7 дугаар зүйл. Бүсийн зөвлөл

7.1. Бүсийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ нь бус нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага мөн.

7.2. Зөвлөл нь дараахь бүрэлдэхүүнтэй байна:

7.2.1. Зөвлөлийн дарга;

7.2.2. тухайн бүсэд багтаж буй аймгийн Засаг дарга;

7.2.3. бүсийн тулгуур төв хотын захирагч;

7.2.4. нийслэлийн хувьд нийслэл, дүүргийн Засаг дарга, дагуул хотын захирагч.

7.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнд дараахь байгууллагын төлөөллийг оруулж болно:

7.3.1. тухайн бүсэд багтаж буй аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

7.3.2. иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны хамтын ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллага;

7.3.3. тухайн бүсийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж буй дотоод, гадаадын хөрөнгө оруулагч байгууллага, аж ахуйн нэгж.

7.4. Нийслэлийнхээс бусад Зөвлөлийн даргын бүрэн эрхийг тухайн бүсэд багтах аймгийн Засаг дарга нараас Монгол Улсын Ерөнхий сайдын томилсон аймгийн Засаг дарга хэрэгжүүлнэ.

7.5. Нийслэлийн бүсийн Зөвлөлийн дарга нь нийслэлийн Засаг дарга байна.

7.6. Ерөнхий сайд тухайн зөвлөлийн даргын саналыг үндэслэн зөвлөлийн бүрэлдэхүүнд орох гишүүдийг Зөвлөл тус бүрээр батална.

## 8 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх

8.1. Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүсийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг жил бүр Үндэсний хороонд тайлагнах;

8.1.2. бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тухайн бүсийг хөгжүүлэх зорилт, арга хэмжээг тодорхойлж эдийн засаг, нийгмийн хөгжлийн жилийн үндсэн чиглэл, дунд хугацааны хөтөлбөрт тусгуулах арга хэмжээ авах;

8.1.3. тухайн бүсийн хэмжээнд төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн ажлыг нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;

8.1.4. тухайн бүсийн хөгжлийн асуудлаар холбогдох төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний хороонд, шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт санал оруулж шийдвэрлүүлэх;

8.1.5. бүс нутгийн хөгжлийн асуудлаар нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэн, хуулийн этгээдээс тавьсан санал, хүсэлтийг судалж холбогдох арга хэмжээ авах;

8.1.6. тухайн бүсийн хэмжээнд бүс нутгийн хөгжлийн асуудлаар бүсчилсэн зөвлөлтөөн, уулзалт, үзүүлэх сургууль санаачлан зохион байгуулах;

8.1.7. тухайн бүсийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх талаар иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаас тавьж буй санал, санаачлагыг дэмжин зохион байгуулалтын удирдлагаар хангах;



8.1.8. бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулсан аргачлал, зааврын дагуу бүсийн хөгжлийн талаархи судалгаа, мэдээллийг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх;

8.1.9. бүсийн тэжээл тариалах, хадлан хадах талбай болон бэлчээр нутгийг тодорхойлох, байгалийн гамшгаас мал сүргийг урьдчилан сэргийлэх, хамгаалах бүс нутгийн сүлжээ бүрдүүлэх;

8.1.10. бүсийн онцлогтой холбогдсон эдийн засгийн бодлогын асуудлаар саналаа Засгийн газарт тавих;

8.1.11. бүсийн дэд бүтцийг байгуулах, ашиглах асуудлыг санаачлан хэрэгжүүлэх.

8.2. Зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хуулиар нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудлаар шийдвэр гаргуулах шаардлага гарвал уг асуудлыг зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

### 9 дүгээр зүйл. Зөвлөлийн даргын бүрэн эрх

9.1. Зөвлөлийн дарга нь дараахь бүрэн эрхтэй:

9.1.1. Зөвлөлийн ажлыг удирдан зохицуулах;

9.1.2. Зөвлөлийн хурлыг товлон хуралдуулах;

9.1.3. Засгийн газар, Үндэсний хороо, бүсийн Зөвлөлд Зөвлөлийнхөө бүрэн эрхэд хамаарах асуудлаар шийдвэрийн төсөл санаачилж хэлэлцүүлэх.

9.2. Зөвлөлийн дарга эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж, тогтоосон загварын тамга, тэмдэг хэрэглэнэ.

### 10 дугаар зүйл. Зөвлөлийн ажиллах журам

10.1. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хурал байна.

10.2. Зөвлөлийн хурлын дэгийг Зөвлөл өөрөө тогтооно.

10.3. Засгийн газрын санаачилгаар Зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулж болно.

10.4. Зөвлөл өөрийн эрх хэмжээний асуудлаар тогтоол гаргана.

10.5. Зөвлөлийн өдөр тутмын ажлыг Зөвлөлийн даргаар ажиллаж байгаа тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

10.6. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

10.7. Зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар тогтоож мөрдүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаархи төрийн байгууллагуудын бүрэн эрх

#### 11 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

11.1. Улсын Их Хурал нь бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах;

11.1.2. Бүсчилсэн хөгжлийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

11.1.3. эдийн засгийн бүсчлэлийн ерөнхий бүдүүвч, бүсийн тулгуур төвүүдийг тогтоох;

11.1.4. бүсүүдийн хөгжлийн стратегийг хэлэлцэж батлах;

11.1.5. тодорхой бүс нутагт зам тээвэр, эрчим хүч, холбоо, мэдээллийн үндсэн тэнхлэгийн сүлжээг байгуулах бодлогыг тодорхойлох;

11.1.6. бүсийн хөгжлийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах.

#### 12 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

12.1. Засгийн газар бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1. бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;

12.1.2. бүсийн хөгжлийн хөтөлбөрийг батлах, бүсийн хөгжлийн стратегийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

12.1.3. орон нутгийн хөгжлийн төвүүдийг тогтоох;

12.1.4. бүсийн хөгжлийн тулгуур төвүүдийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлах;

12.1.5. бүс нутгийн хөгжлийг хөрөнгө оруулалт, татвар, зээлийн бодлогоор дэмжих арга, хэлбэрийг судлан тогтоож, саналаа Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэх;

12.1.6. бүс нутгийн хөгжлийн асуудлаар төрийн захиргааны төв байгууллага, Зөвлөлүүдийн хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

12.1.7. бүсийн хөгжлийн талаархи олон улсын гэрээ, хэлэлцээрийг байгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;

12.1.8. бүс нутгийн хөгжилд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих;

12.1.9. дэд бүтцийн үндсэн тэнжлэгийн замуудыг барьж байгуулах ажлыг бүс нутгийн хөгжлийн бодлогод нийцүүлэх.

### **13 дугаар зүйл. Бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

13.1. Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бүс нутгийн хөгжлийн асуудлыг хариуцаж дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. бүсийн хөгжлийн стратегийг боловсруулан Засгийн газарт оруулах;

13.1.2. бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан аймаг, нийслэлийн болон сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулахад

мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

13.1.3. бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагын оролцоог өргөжүүлэх арга хэмжээ авах;

13.1.4. бүс нутгийн хөгжлийн тодорхой асуудлаар судалгаа шинжилгээний төсөл захиалах, тендэрт шалгарсан төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

13.1.5. Үндэсний хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах;

13.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

### **14 дүгээр зүйл. Төрийн захиргааны бусад төв байгууллагын бүрэн эрх**

14.1. Төрийн захиргааны бусад төв байгууллага нь бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан салбарын хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг боловсруулж хэрэгжүүлэх;

14.1.2. эдийн засгийн бүсчлэлийн ерөнхий бүдүүвчтэй уялдуулан салбарын бүсчлэл, байршлын бүдүүвчийг тогтоож, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжил, байршлыг зохицуулах;

14.1.3. бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар тухайн салбарын хүрээнд явуулж байгаа үйл ажиллагааг Үндэсний хороонд тайлагнах;

14.1.4. салбарын хүрээний асуудлаар Зөвлөлүүдийн ажлыг уялдуулан зохицуулж, мэргэжлийн зөвлөгөө, шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах;

14.1.5. салбарын зорилтыг бүс нутгийн хөгжлийн асуудалтай уялдуулах зорилгоор бүсчилсэн зөвлөлгөөн, уулзалт санаачлан зохион байгуулах;

14.1.6. бүс нутгийн хөгжлийн

асуудлаар салбарынхаа хүрээнд судалгаа, шинжилгээ хийх, зураг төсөв зохиож төслийн тендер зарлаж, шалгарсан төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

14.1.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаархи нутгийн удирдлагын байгууллагын бүрэн эрх**

**15 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх.**

15.1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1. бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсийн хөгжлийн стратегитэй уялдуулан нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал, хэтийн төлөвийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

15.1.2. бүс нутгийн хөгжлийн асуудлаар Засаг даргын тайланг хэлэлцэх;

15.1.3. бүсийн хөгжлийн нийтлэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор тухайн бүсэд багтах бусад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран ажиллах;

15.1.4. бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын оролцоог дэмжин чиглүүлэх;

15.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

15.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.2.1. Зөвлөлийн даргаар томилогдон ажиллах хугацаанд Зөвлөлийн даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

15.2.2. тухайн бүс нутгийн хөгжлийн асуудлаар Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, түүний үйл ажиллагаанд бүх талын

дэмжлэг үзүүлэх;

15.2.3. бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтын нь дагуу үр ашигтай ашиглах;

15.2.4. Бүс нутгийн хөгжлийн талаар хийж байгаа ажлын үр дүнг Зөвлөлд тайлагнах;

15.2.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

**16 дугаар зүйл. Бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт**

16.1. Бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

16.1.1. улсын болон орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө;

16.1.2. гадаад улс, олон улсын байгууллагын зээл, хандив, тусламжийн хөрөнгө;

16.1.3. иргэн, хуулийн этгээдийн бүс нутгийн хөгжилд зориулан олгосон зээл, хандив, тусламжийн хөрөнгө.

16.2. Энэ хуулийн 16.1-д заасан хөрөнгийг тухайн бүсийн хөгжлийг дэмжих санд төвлөрүүлэн, Зөвлөлийн шийдвэрийн дагуу Зөвлөлийн дарга зарцуулах бөгөөд уг санг байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг Засгийн газар тогтооно.

### 17 дугаар зүйл. Бүсийн хэлэлцээр

17.1. Улсын болон бүс нутгийн хөгжлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд Засгийн газар, түүнийг төлөөлж төрийн захиргааны холбогдох төв байгууллага, бүсийн хэмжээнд Зөвлөл нь бүсийн хэлэлцээрийг байгуулан ажиллаж болно.

17.2. Бүсийн хэлэлцээрээр дор дурдсан асуудлыг зохицуулна:

17.2.1. улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр тухайн бүсэд дэд



бүтцийг байгуулах;

17.2.2. тухайн бүсийн байгалийн баялгийг зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах;

17.2.3. тухайн бүсийн хэмжээнд хүн амын суурьшил, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах;

17.2.4. бүсийн хөгжлийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв, хотуудыг тохижуулж хөгжүүлэх;

17.2.5. гадаад улс, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

17.2.6. тухайн бүсээс экспортод нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ, зах зээлийг зохицуулах.

17.3. Бүсийн хэлэлцээр байгуулах нийтлэг журмыг Засгийн газар тогтооно.

17.4. Бүсийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт

оруулах асуудлыг түүнд тодорхойлсон нөхцөл, болзлын дагуу талууд тохиролцсоноор шийдвэрлэх бөгөөд түүний биелэлтэд оролцогч талууд, Засгийн газар, Зөвлөл хяналт тавина.

17.5. Бүсийн хэлэлцээрээр нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хөндөж байвал уг асуудлаар тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөж нэгдсэн санал дүгнэлтэд хүрсэн байна.

## 18 дугаар зүйл. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын асуудлаар үүссэн маргааныг шийдвэрлэх

18.1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын асуудлаар төрийн азахиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, Зөвлөлийн хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Засгийн газар шийдвэрлэнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### АГААРЫН ЗАЙГ НИСЭХЭД АШИГЛАХ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын агаарын зайг нисэхэд ашиглах, Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль тогтоомж

2.1. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль тогтоомж нь энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь Монгол Улсын агаарын

зайг иргэний болон улсын нисэхэд ашиглахад үйлчилнэ.

#### 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "Монгол Улсын агаарын зай" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээшхи хийн мандлын агаарын давхрагын орон зайг;

4.1.2. "хилийн агаарын бүс" гэж улсын хилийн шугамаас дотогш 30 км-ын өргөнтэй нутаг дэвсгэр дээрх агаарын зайг;

4.1.3. "аюултай бүс" гэж тусгайлан заасан хугацаанд нислэгийн үйл ажиллагаанд аюул учруулж болзошгүй, тодорхой өндөр болон өргөнөөр хязгаарлагдсан агаарын зайг;

4.1.4. "хязгаарлалттай бүс" гэж агаарын хөлгийн нислэгийг хязгаарлах зорилгоор тогтоосон, тодорхой өндөр болон өргөнөөр хязгаарлагдсан агаарын зайг;



4.1.5. "хориотой бүс" гэж агаарын хөлгийн нислэгийг хориглосон, тодорхой өндөр болон өргөнөөр хязгаарлагдсан агаарын зайг;

4.1.6. "цэргийн зориулалтын бүс" гэж цэргийн үйл ажиллагаа явуулахад зориулан тогтоосон, өндөр болон өргөнөөр хязгаарлагдсан агаарын зайг;

4.1.7. "агаарын зайн аюулгүй байдал" гэж Монгол Улсын агаарын зайн халдашгүй дархан байдлыг хөндлөнгийн, хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон цогцолбор арга хэмжээг;

4.2. Энэ хуульд заасан бусад нэр томъёог Иргэний нисэхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан нэр томъёотой нэгэн адил утгаар ойлгоно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Агаарын зайг нисэхэд ашиглах, хяналт тавих

#### 5 дугаар зүйл. Агаарын зайг нисэхэд ашиглах зохицуулалт

5.1. Монгол Улсын Засгийн газраас агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журмыг тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавина.

5.2. Энэ хуулийн 5.1-д заасан журмаар дараахь үйл ажиллагааг зохицуулна:

5.2.1. нисэхэд ашиглах агаарын зайн ангиллыг тогтоох;

5.2.2. агаарын зайн хяналт;

5.2.3. нисэхэд ашиглах агаарын зайн аюулгүй байдлыг хангах;

5.2.4. агаарын зайн ашиглалтын зохицуулалт хийх;

5.2.5. Монгол Улсын агаарын зайг хүмүүнлэгийн олон улсын үйл ажиллагаанд зориулан ашиглуулах;

5.2.6. хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагаа.

5.3. Монгол Улсын агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журмын хэрэгжилтийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тусын чиг үүргийн дагуу хангана.

#### 6 дугаар зүйл. Нисэхэд ашиглах агаарын зайг тогтоох

6.1. Иргэний нисэхэд ашиглах агаарын зайг олон улсын хэм хэмжээ, иргэний нисэхийн үйл ажиллагаанд нийцүүлэн иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

6.2. Улсын нисэхэд ашиглах агаарын зайг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

6.3. Монгол Улсын агаарын зайд улсын нисэхэд ашиглах агаарын зам тогтоох, агаарын хаалгыг шинээр нээх, хаах асуудлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

6.4. Монгол Улсын агаарын зайд иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын зам, агаарын хаалгыг Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т заасны дагуу тогтоох бөгөөд уг асуудлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авсан байна.

#### 7 дугаар зүйл. Агаарын зайн аюулгүй байдлын хяналт

7.1. Агаарын зайн аюулгүй байдлын хяналт нь агаарын зайн зөрчлийг илрүүлэх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагаанаас бүрдэнэ.

7.2. Энэ хуулийн 7.1-д заасан үйл ажиллагааг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага хэрэгжүүлнэ.

7.3. Монгол Улсын агаарын зайн зөрчлийг илрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ радиолокаци бүхий хяналтын хэрэгслээр гүйцэтгэнэ.

#### 8 дугаар зүйл. Агаарын зайн зөрчил

8.1. Дараахь үйлдлүүдийг агаарын зайн зөрчил гэнэ:

8.1.1. нислэгийн хөдөлгөөнийг удирдах эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй нислэг үйлдэх;

8.1.2. аргагүйдсэнээс бусад тохиолдолд агаарын хөлөг нислэгийн хөдөлгөөнийг удирдах эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй буулт үйлдэх;

8.1.3. тогтоогдсон журмыг зөрчин Монгол Улсын агаарын хаалгаар нэвтрэх;



8.1.4. Монгол Улсын хилийн агаарын бусад зөвшөөрөлгүй нислэг үйлдэх;

8.1.5. хориотой, хязгаарлалттай, аюултай, цэргийн зориулалтын бусад нислэгийн хөдөлгөөнийг удирдах эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй нислэг үйлдэх;

8.1.6. агаарын хилээр орж ирсэн тагнуулын зориулалттай нисэх хэрэгслүүдийн нислэг.

8.2. Энэ хуулийн 8.1.2 дахь заалт байлдааны үүргийн нислэгт хамаарахгүй.

### **9 дүгээр зүйл. Нисэхэд ашиглах агаарын зайн аюулгүй байдлыг хангах**

9.1. Монгол Улсын агаарын зайд цэргийн зориулалттай буудлага, дэлбэлэлт хийх, пуужин харвах зэргээр нислэгт аюул учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахад цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага Иргэний нисэхийн ерөнхий газартай зөвшилцөнө.

9.2. Агаарын довтолгооноос хамгаалах зорилгоор байлдааны зориулалтаар пуужин харвах, буудлага үйлдэхэд энэ хуулийн 9.1 дэх заалт хамаарахгүй.

9.3. Аливаа агаарын хөлөг Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх үедээ хууль бус үйлдэлд өртөж, бусдын эрхшээлд орсон тохиолдолд цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1. агаарын хөлгийг булаан авч, нисэх багийг эрхшээлдээ оруулсан этгээдэд агаарын хөлгийг ойролцоох нисэх буудалд буулгахыг шаардах;

9.3.2. хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлгийн асуудлаар иргэний нисэхийн удирдлага болон нислэг хөдөлгөөний үйлчилгээний албанд үүрэг, даалгавар өгөх;

9.3.3. агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийг харьяалал харгалзахгүйгээр ойролцоох нисэх буудалд яаралтай буулгах арга хэмжээ авах;

9.3.4. аюулд нэрвэгдсэн гадаад орны агаарын хөлөгт тусламж үзүүлэх бололцоотой арга хэмжээг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу авч хэрэгжүүлэх;

9.3.5. хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлөг ойролцоох нисэх буудалд осол эндэлгүй буух шаардлагыг үл хэрэгсэн нислэгээ үргэлжлүүлбэл дараагийн учирч болзошгүй уршиг, үр дагавраас сэргийлэх зорилгоор Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах;

9.3.6. зэвсэгт хүчний агаарын довтолгооноос хамгаалах анги, салбаруудын жижүүрлэлтийн хүч хэрэгслийг нэмэгдүүлэх.

### **10 дугаар зүйл. Дайны байдлын үеийн зохицуулалт**

10.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт дайны байдал зарласан үед нисэх хэрэгслийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Монгол Улсын Зэвсэгт хүчний мэдэлд шилжүүлэхтэй холбогдсон харилцааг Дайчилгааны тухай хуулиар зохицуулна.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

#### **Бусад зүйл**

### **11 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

11.1. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд зүүгийн хариуцлага хүлээлгэхээрэй бол шүүгч дор дурдсан хариуцлагыг хүлээлгэнэ:

11.1.1. агаарын зайг нисэхэд ашиглах журмыг зөрчсөн албан тушаалтныг 50000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-200000 төгрөгөөр тус тус торгох;

11.1.2. агаарын зайн хяналтын үед илэрсэн зөрчлийг таслан зогсоох ажиллагааг хэтрүүлэн хэрэгжүүлснээс бусдад хохирол учруулсан бол гэм буруутай албан тушаалтныг 50000-60000 төгрөгөөр торгох;

11.1.3. энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан зөрчил гаргасан агаарын хөлгийн багийн даргыг 50000-60000 төгрөгөөр торгох.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

### УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Улсын нисэхийн тухай хууль тогтоомж

2.1. Улсын нисэхийн тухай хууль тогтоомж нь энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар улсын нисэхийн үйл ажиллагааг зохицуулна.

##### 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "аюул тулгарсан агаарын хөлөг" гэж агаарын хөлөг болон зорчигчдод аюул учирч, түүнийг нисэх баг өөрийн үйл ажиллагаагаар арилгаж чадахгүйд хүрсэн, эсхүл агаарын хөлөг холбоогүй буюу байрлал нь тодорхой бус болсон;

4.1.2. "аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг" гэж явгалалт, хөөрөлт, буулт, нислэгийн үед гэмтэж аргагүйдсэн буулт үйлдсэн, эсхүл бүрэн эвдэрсэн;

4.1.3. "улсын нисэх" гэж улсын агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбогдсон цогцолбор ойлголтыг;

4.1.4. "улсын агаарын хөлөг" гэж цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын агаарын хөлгийг;

4.1.5. "байлдааны агаарын хөлөг" гэж байлдаанд ашиглах зориулалтаар зэвсэг, галт хэрэгсэл, тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон агаарын хөлгийг.

4.2. Энэ хуульд заасан бусад нэр томъёог

Иргэний нисэхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан нэр томъёотой нэгэн адил утгаар ойлгоно.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ

##### Улсын нисэхийн үйл ажиллагааг төрөөс зохицуулах

##### 5 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

5.1. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. улсын нисэхийн нислэгийн үйл ажиллагааны журмыг холбогдох байгууллагатай зөвшилцөж батлах;

5.1.2. улсын нисэхийн бүтэц, зохион байгуулалтыг батлах;

5.1.3. улсын нисэхийн багц дүрмийг батлах.

##### 6 дугаар зүйл. Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагын чиг үүрэг

6.1. Улсын нисэхийн үйл ажиллагаа цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагын хяналтанд байна.

6.2. Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага энэ хуулийн хэрэгжилтэнд мэргэжлийн хяналт тавьж, дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.2.1. улсын нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах арга хэмжээг зохион байгуулах;

6.2.2. улсын нисэхийн дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавих;

6.2.3. тогтоосон агаарын хаалгаас гадуур нэвтрэх агаарын хөлөгт зөвшөөрөл олгох.

##### 7 дугаар зүйл. Улсын нисэхийн багц дүрэм

7.1. Улсын нисэхийн багц дүрмээр дараахь харилцааг зохицуулна:

7.1.1. улсын агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх;

7.1.2. нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох;

7.1.3. улсын агаарын хөлгийн таних тэмдэг, түүнийг батлах, тооллогын дугаар олгох,



байрлуулах;

7.1.4. улсын нисэхийн агаарын хөлгийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах;

7.1.5. улсын нисэхийн аэродромуудын бүсэд нислэг үйлдэх болон тэдгээрийг ашиглах;

7.1.6. эрэн хайх, авран туслах ажлыг зохион байгуулах;

7.1.7. улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагаанд хяналт тавих;

7.1.8. улсын агаарын хөлгийн ашиглалт, үйл ажиллагаанд хяналт тавих, үзлэг шалгалт хийх;

7.1.9. улсын агаарын хөлгийн нисэх багц мэргэжлийн үнэмлэх олгох;

7.1.10. хууль тогтоомжид заасан бусад харилцаа.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Улсын агаарын хөлөг, түүний нислэг

#### 8 дугаар зүйл. Улсын агаарын хөлгийг бүртгэх

8.1. Улсын агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох бүрэн эрхийг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага хэрэгжүүлнэ.

#### 9 дүгээр зүйл. Улсын агаарын хөлгийн дарга, нисэх баг

9.1. Улсын агаарын хөлгийн багийн дарга, нисэх багийг уг агаарын хөлгийг ашиглагч эрх бүхий байгууллага томилно.

9.2. Улсын агаарын хөлгийн нисэх багийн гишүүд цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагаас олгосон мэргэжлийн, хүчин төгөлдөр үнэмлэхтэй байна.

9.3. Улсын агаарын хөлгийн дарга нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1. байлдааны үүргийн нислэг гүйцэтгэхээс бусад тохиолдолд Иргэний нисэхийн тухай хуулийн 18.2-т заасан бүрэн эрх;

9.3.2. байлдааны үүргийн нислэг гүйцэтгэж байгаа үедээ командлалаас өгсөн үүргийг биелүүлэх зорилгоор энэ хуульд заасан дүрэм, журамд зааснаас өөр шийдвэр гаргах.

#### 10 дугаар зүйл. Улсын агаарын хөлгийн нислэгийн ангилал

10.1. Улсын агаарын хөлгийн нислэг

дараахь ангилалтай байна:

10.1.1. байлдааны үүргийн нислэг;

10.1.2. онцгой үүргийн нислэг;

10.1.3. тусгай үүргийн нислэг;

10.1.4. арилжааны нислэг.

10.2. Байлдааны үүргийн нислэгт байлдааны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон бүх төрлийн нислэгүүд хамаарна.

10.3. Онцгой үүргийн нислэгт дараахь нислэгүүд хамаарна:

10.3.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын өндөр хэмжээний зочдоод үйлчлэх нислэг;

10.3.2. тогтоосон агаарын замаас гадна зөвшөөрөгч шаардлагатай үйлдэх улсын агаарын хөлгийн нислэг.

10.4. Тусгай үүргийн нислэгт тайван цагийн батлан хамгаалах нислэг, хил хамгаалалт, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэхтэй холбогдолтой нислэг болон байгалийн гамшиг, хүн, малын гоц халдварт болон ургамлын онц хөнөөлт өвчинтэй тэмцэх, эмнэлгийн яаралтай, түргэн тусламжийн зорилгоор үйлдэж буй бүх төрлийн нислэгүүд хамаарна.

10.5. Улсын агаарын хөлгөөр арилжааны нислэг үйлдэх бол Иргэний нисэхийн тухай хуулийг баримтална.

#### 11 дүгээр зүйл. Улсын агаарын хөлгийн нислэгийн зохицуулалт

11.1. Улсын агаарын хөлгийн байлдааны үүргийн нислэгийн зохицуулалтыг Улсын нисэхийн нислэгийн хөдөлгөөний алба хэрэгжүүлнэ.

11.2. Улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалтыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтарсан журмаар хэрэгжүүлнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Улсын нисэхийн аэродромын ашиглалт

#### 12 дугаар зүйл. Улсын агаарын хөлөг байрлах аэродром

12.1. Улсын нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг Улсын нисэхийн багц дүрмээр тогтооно.

12.2. Цэргийн зориулалттай нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ.

12.3. Улсын нисэхийн аэродромын бүртгэлийг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага эрхэлнэ.

12.4. Улсын нисэхийн аэродромын орчмын нутаг дэвсгэрийн гадна барилга байгууламж барих, холбооны болон өндөр хүчдэлийн шугам тавих асуудлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан тохиролцож шийдвэрлэнэ.

## 13 дугаар зүйл. Аэродромыг хамтран ашиглах

13.1. Улсын болон иргэний агаарын хөлгүүд хамтран ашиглах аэродром нь иргэний нисэхийн аэродромд тавигддаг бүх шаардлагыг хангасан байна.

13.2. Улсын нисэхийн аэродромыг хамтран ашиглах журмыг батлан хамгаалах болон иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Улсын нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал

#### 14 дүгээр зүйл. Улсын нисэхийн аюулгүй ажиллагааг хангах

14.1. Улсын агаарын хөлгийг бүртгэх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, инженер, техникийн бүрэлдэхүүнийг батламжлах зэрэг журмыг Улсын нисэхийн багц дүрмээр тогтооно.

14.2. Улсын нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол зорчигчдын бие болон гар тээшинд агаарын хөлгийг эзэмшигч болон холбогдох мэргэжлийн байгууллага зохих зааврын дагуу үзлэг хийх эрхтэй.

14.3. Энэ хуулийн 14.2-т заасан үзлэгээс татгалзсан үйлчлүүлэгчийг тээвэрлэхийг хориглох ба шаардлагатай гэж үзвэл эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

14.4. Хилийн агаарын бусад нислэг үйлдэх зөвшөөрлийг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага хил хамгаалах байгууллагыг удирдах байгууллагатай хамтран олгоно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Эрэн хайх, авран туслах ажил

#### 15 дугаар зүйл. Эрэн хайх, авран туслах ажлыг зохион байгуулах

15.1. Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, түүний нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, тусламж үзүүлэх, тэдгээрийг ослын газраас шилжүүлэн зөвөөрлөх ажиллагааг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

#### 16 дугаар зүйл. Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа

16.1. Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага тухайн агаарын хөлөг эзэмшигчтэй хамтран тусгайлан бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ.

16.2. Эрэн хайх, авран туслах нислэгийг улсын болон иргэний нисэхийн байгууллагууд хамтран гүйцэтгэж болно.

16.3. Орон нутгийн засаг захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлгийн талаар өөрт мэдэгдсэн мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх, нисэх баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, түүнчлэн агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүрэгтэй.

#### 17 дугаар зүйл. Аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх ажлыг зогсоох

17.1. Аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх бүх арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд эргийн ажлыг зогсоох шийдвэрийг уг агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах

#### 18 дугаар зүйл. Улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах

18.1. Улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийн урьдчилсан нөхцөл үүссэн тухай асуудлыг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг улсын нисэхийн нислэг-техникийн шинжлэн шалгах комисс гүйцэтгэх бөгөөд бүрэлдэхүүнийг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.2. Улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах комисс нь гарсан осол зөрчлийн нөхцөл, шалтгааныг тогтоож, цаашид уг осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

18.3. Улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийн шалтгааныг тогтоох, шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай гэж үзвэл иргэний нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албаны болон гадаадын мэргэжлийн хүмүүсийг оролцуулж, хамтарсан комисс томилол шалгаж болно.

## 19 дүгээр зүйл. Улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шалгах шинжээчийн бүрэн эрх

19.1. Улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шалгах шинжээч нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1. улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой газруудад саадгүй нэвтрэх;

19.1.2. улсын нисэхийн багц дүрэмд өөрчлөлт оруулах санал гаргах;

19.1.3. улсын нисэхийн анги, байгууллагын нислэгийн бэлтгэл, гүйцэтгэлд үнэлэлт өгөх;

19.1.4. улсын нисэхийн техникийн ашиглалтын горимд хяналт тавьж дүгнэлт гаргахад зөвлөмж өгөх;

19.1.5. улсын агаарын хөлгийн нислэг-техникийн осол зөрчлийн шалтгааныг үнэн зөв тогтоох, шаардлагатай мэдээ, судалгаа, бусад баримт бичгийг холбогдох этгээдээс шаардан гаргуулж авах.

## НАЙМДУГААР БҮЛЭГ Бусад зүйл

### 20 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

20.1. Улсын нисэхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дор дурдсан хариуцлага

хүлээлгэнэ:

20.1.1. улсын нисэхийн багц дүрэмд заасан бичиг баримтын бүрдэлгүй, эсхүл зөвшөөрөлгүйгээр нисэхийн үйл ажиллагаа эрхэлсэн албан тушаалтныг 60000, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр тус тус торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

20.1.2. энэ хуулиар эрх олгогдсон этгээд нислэгийн аюулгүй байдлын болон аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалтыг зохих журмын дагуу хийгээгүй бол 45000-50000 төгрөгөөр торгож, үзлэг шалгалт хийх эрхийг 1 жил хүртэл хугацаагаар хасах;

20.1.3. улсын нисэхийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг зөрчсөн албан тушаалтныг 50000-60000, байгууллагыг 150000-200000 төгрөгөөр тус тус торгож, нисэхийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 1 жил хүртэл хугацаагаар хасах;

20.1.4. байлдааны нислэгээс бусад нислэгийн үед нислэгийг хэвээр үргэлжлүүлэх боломжгүй онцгой тохиолдлын талаар нислэгийн удирдагчид мэдээлээгүй агаарын хөлгийн даргыг 50000-60000 төгрөгөөр торгож, мэргэжлийн эрхийг 1 жил хүртэл хугацаагаар хасах;

20.1.5. улсын нисэхийн үйл ажиллагаа явуулдаг бусад хууль бусаар нэвтэрсэн этгээдийг 50000, мал оруулсан этгээдийг 25000 төгрөгөөр тус тус торгох;

20.1.6. улсын агаарын хөлгийн үйл ажиллагааны журам зөрчсөний улмаас хохирол учруулсан бол гэм буруутай албан тушаалтныг 50000-60000 төгрөгөөр торгож, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг 1 жил хүртэл хугацаагаар хасах, байгууллагыг 150000-200000 төгрөгөөр торгох.

20.2. Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ улсын нисэхийн эд хөрөнгөд хохирол учруулсан гэм буруутай этгээдэд Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуулийн дагуу эд хөрөнгийн хариуцлага ногдуулна.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний нисэхийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 4.3 дахь хэсэг нэмсүгэй:

"4.3. Энэ хуулийн 4.2 дахь хэсэг байлдааны үүргийн нислэгийн хөдөлгөөнд хамаарахгүй."

2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хуулийн 3.1.9-ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.1.9. "улсын агаарын хөлөг" гэж цэрэг,

цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын агаарын хөлөг".

3 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хуулийн 26.1-ийн "агаарын зайд" гэснийг "иргэний нисэхийн зориулалтаар ашиглаж буй агаарын зай болон агаарын замд" гэж өөрчилсүгэй.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

**Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

10 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

1. Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлыг 2004 оны

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

**Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.13-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

ажиллах журмыг тогтоон мөрдүүлэх ажлыг 2003 оны 4 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэх;

1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

4/ Бүсчилсэн хөгжлийн удирдлага

зохицуулалтын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх арга замыг бүх нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авах.

1/ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авах;

2. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг орон нутагт сурталчлах, түүнийг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгасугай.

2/ Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нийцүүлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд шинээр боловсруулан гаргах болон нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн жагсаалтыг Улсын Их Хурлын 2003 оны намрын чуулганд танилцуулах;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Т.Очирхүү/-нд даалгасугай.

3/ Үндэсний хорооны гишүүд болон бүсийн Зөвлөлийн дарга нарыг томилох, тэдгээрийн

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 2.5

☎ 329487